



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 1/477

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8.1.1, 8.1.3, 8.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Парис-2024” зуны олимпын наадмын медальт, 2024 оны дэлхийн аварга, Ази тивийн аварга, Душанбегийн их дуулгын аварга, Олон улсын хэмжээний мастер, Монгол улсын гавьяат тамирчин Б.Баасанхүүгийн нэрэмжит “Жудо” бөхийн өсвөр үеийн анхдугаар тэмцээнийг зохион байгуулах Ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжилт, үр дүнг тайлагнаж ажиллахыг Ажлын хэсгийн дарга (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.


3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
09 дүгээр сарын 16-ны өдрийн
А/477 дугаар захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга : Э.Улам-Өсөх (Тамгын газрын даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Б.Очирбат (Биеийн тамир, спортын газрын дарга)
 О.Бадраа (Боловсролын газрын дарга)
 Ч.Дашбаяр (Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга)
 Л.Батцэцэг (Соёл, урлагийн газрын дарга)
 Б.Баасансүрэн (Хилийн цэргийн 0257 ангийн дарга, хурандаа)
 Б.Хөвсгөл (Эрүүл мэндийн газрын Нийтийн биеийн тамир, чийрэгжилт
хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Б.Хүрэлбаатар (Биеийн тамир, спортын газрын сургалтын албаны дарга)

_____оОо_____